Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

# БАЯНЦОГТ СУМЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙЦААГЧ К.ДУЛМААГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт,арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (Биелэлт) | Эхэлсэн, Дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1:** Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд шатны байгууллагаас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана. | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцож ажилласан байна. | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн дагуу НДЕГ-ын 2023.12.28-190-А/194 тэтгэмжийн бүрдүүлэх баримт бичгийн хяналтын журам,2024.02.29-01/403 НДШ төлөлт тайлагнах, малчны зөвлөл, 2024.04.04-04/702-тэтгэврийн итгэлцүүр, 2024.03.15-01/514-НДШимтгэлийн тайлан авах ажлыг зохион байгуулах, 2024.05.20-04/1054-НД-ын хамрагдалтыг нэмэгдүүлэх жил болгон уралдаан зарласан, 2024.05.15-01/1020-Callpro үйлчилгээ, 2024.06.10-01/1200 Хоршоо, 2024.06.07-04/1187 сонгуулийн ухуулагч нар нь Нийгмийн даатгалын хуулийг хэрхэн хэрэгжүүлэн ажиллах талаар батлагдсан дүрэм, журам, заавар,зөвлөмж, аргачлалтай танилцаж даатгуулагч нарт сургалт сурталчилгааг 8 удаа хийж 1050 иргэн хамрагдсан байна. Мөн Засгийн газрын 2024.03.20-120 тогтоолын дагуу тэтгэврийн нэмэгдэлийг нийт 394 өндөр нас, болон хөдөлмөрийн чадвар түр алдсан, тэжээгчээ алдсаны тэтгэврийн хувийн хэрэгт бичилт хийж баталгаажуулсан. | 1-12сар | |
| | Арга хэмжээ 1.2 Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан | | Хавсралт судалгаагаар | Сайн дурын даатгалын жилийн төлөвлөгөө 167 даатгуулагчийг хамруулж 142,9 сая төгрөгний орлоготой ажиллахаас 4-р улирлын байдлаар 169 | 1-12 сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 0-3 хүртэл насны хүүхдээ асарч байгаа эхчүүд, малчид, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажилгүй байгаа эцэг, эх, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | даатгуулагчийн тоо, дээд газарт хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо | | | иргэнийг хамруулж орлого 86,4 сая төгрөгийг оруулж, гэрээ байгуулан мэдээллийн санд бүртгэсэн . үүнээс: малчин-108, ажилгүй-45, 0-3насны хүүхэдтэй эх 16 даатгуулагч тус тус хамрагдсан. Суманд хөгжлийн бэрхшээлтэй 2 хүүхэд байдаг боловч эцэг, эх нь ажил хийдэг тул энэ хуулийн хүрээнд хамрагдалт байхгүй байна. | | |
| | Арга хэмжээ 1.3 Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг илрүүлж шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо | | Ажил олгогчийн тоо, даатгуулагчийн тоог нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна | Татварт бүртгэлтэй суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Галбын говийн жинчин” “Дэвхрэгчулуут”,”Ургац мандала”,”Буянт буудай арвижих” гэсэн 4 аж ахуйн нэгжийг шинээр нийгмийн даатгалд хамруулж, 4 даатгуулагч албан журмын даатгалд хамрагдаж цахимаар тайланг илгээж мэдээллийн сан үүсгэн ажилласан. | 1-12 сар | |
| | Арга хэмжээ 1.4 “Өв соёлоо эрхэмлэж үндэсний бичгээ сурцгаая” аяны хүрээнд монгол хэл, бичгийн чадвараа дээшлүүлнэ. | Албан хаагчид монгол бичгийн сургалтад хамрагдсан байна. | | 2 удаа | Байгууллагын дотоод сургалтаар монгол бичгийн хичээлийг сургуулийн Монгол хэл бичгийн багш 14 хоногт 1удаа заадаг энэ сургалтанд хамрагдаж байгаа бөгөөд хувиараа мэдлэгээ дээшлүүлэхээр ажиллаж байна.<br>Монгол бичгийн гарын драйверт монгол бичгийн фондыг нэмсэн, монгол бичгийн гарын байрлал харах хэрхэн бичих талаар цахимаас видио бичлэг зэргийг үзэж судлаж байна. Мөн Нийгмийн даатгалын байцаагчийн шалгалт монгол бичгээр хангалттай гэсэн үнэлгээтэй өгсөн. | 1-12 сар | |
| | Арга хэмжээ 1.5 Шинэ сэргэлтийн бодлого, төрийн бүтээмж дээшлүүлэх зорилт арга хэмжээний хүрээнд тоон гарын үсэг олгох, тоон | Шимтгэл төлөгч буюу ажил олгогч нар тоон гарын үсэг олгон төрийн үйлчилгээнд | | Шинээр тоон гарын үсгээр тайлан илгээх ААН-ийн тоог 5-д хүргэнэ. | Аймгийн 2022 онд дэвшүүлсэн урианы жилийн ажлын хүрээнд сумын ажил олгогч төсвийн 6 байгууллага, аж ахуйн нэгжийн 4 ажил олгогч нийт 10 АО хүсэлт гаргаж тоон гарын үсэг олгон Цахим Монгол хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажилласан. | 1-12 сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | гарын үсгээр тайлан хүлээн авах ажлыг эрчимжүүлэн ажиллана. | түргэн, шуурхай хамрагдах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах. | | | | | |
| | **Зорилт 2: ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | |
| | Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах | | | | | | |
| 2. | Арга хэмжээ 2.1 Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлнэ. | Батлагдсан сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг биелүүлж ажилласан байна. | | -ын шимтгэлийн төлөвлөгөөг сар,улирал,жилээр биелүүлж, 100% биелүүлсэн байна. | Нийгмийн даатгалын сангуудын орлогын 2024 оны төсвийн хуваарь 594,6 сая төгрөгөөр батлагдсан. 2024 оны жилийн эцэст 627,3 сая төгрөг оруулж биелэлтийг сарын өссөн дүнгээр жигд хангаж биелүүлэн ажилласан. | 1-12сар | |
| | Арга хэмжээ 2.2 Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдлээс 30-аас доошгүй хувь бууруулж ажиллана. | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | | НД-ын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30%-аас доошгүй буурсан байна. | 2023 оны эцэс болон 2024 оны эхний өр авлага 4 ажил олгогчийн 151474 төгрөгийг 1 сард барагдуулсан бөгөөд 2024 оны 4-р улирлын байдлаар аж ахуйн нэгжүүд өргүй тайлан өгч ажилласан. | 1-12 сар | - |
| | Арга хэмжээ 2.3 Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулна. | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | | СДД-ншимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | Нийгмийн даатгалд сайн дурын даатгуулагч 4-р улирлын байдлаар 82 иргэн хамрагдсан бөгөөд илүү дутуу тооцоотойг 4-улирлын тайлангаар 27 иргэний 562000 төгрөгийн үлдэгдлийг тооцоо тааруулан үлдэгдлийг арилгаж ажилласан. | 1-12 сар | |
| | Арга хэмжээ 2.4 Бусад өглөг, авлагыг барагдуулна. | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | | НД-ын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50% доошгүй барагдуулах | Нийгмийн даатгалын шимтгэлийн бусад авлага, өглөг нь шинээр нэмж үүсгэсэн авлага, өглөг байхгүй байна.Аймгийн Нийгмийн даатгалын газарт 3 хоног ажиллаж бусад өр авлагыг жагсаалтаар гаргаж тайлбар хийж санхүүгийн албатай тооцоог тааруулж гарын үсэг зурж хүлээлцэн дуусгасан. | 1-12 сар | |
| | Арга хэмжээ 2.5 Тэтгэврийн даатгалын | Үйлчилгээ авсан даатгуулагчийн | | Үйлчилгээ авсан | Тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан 25 иргэний шаардлага хангасан материалыг хүлээн авч хувийн | 1-12 сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сан, тэтгэмжийн даатгалын сан, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах иргэдийн хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд нь шийдвэрлэнэ. | тоо, үйлчилгээний төрөл тус бүрээр | | даатгуулагчийн тоогоор | хэрэг үүсгэн, аймагт хянуулан тогтоолт хийлгэж, олголтыг тухайн хугацаанд багтаан тэтгэвэр авагчдад олгож ажилласан. үүнд: өндөр настан-хэвийн-19, малчин-6 иргэнд тус тус тогтоосон бөгөөд иргэдээс ямар нэгэн гомдол санал ирээгүй болно. Батлагдсан маягтын дагуу сар бүрийн 20-25-ны дотор тэтгэврийн хөдөлгөөний мэдээг 12 удаа өгч гарын үсэг зурж, баталгаажуулан, скайнердаж аймагт тэтгэвэр хариуцсан байцаагчид хүргүүлэн ажилласан. Жирэмсэн амаржсаны тэтгэмжийг 7 эх-17,9 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдалт-8 даатгуулагч 1,2 төгрөг, өндөр настан 8 иргэн оршуулгын 16 сая төгрөг, 8 даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмж 27,5 сая төгрөгийн тэтгэмжийг тус тус олгосон бөгөөд цаасан болон цахимаар хүсэлт гаргаж үйлчилгээ үзүүлсэн байна. | | |
| | Арга хэмжээ 2.6 Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана. | Даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл”-өөр хэлэлцэн шийдвэрлүүлсэн байна | | “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл”-өөр орсон даатгуулагчийн тоогоор | Даатгуулагчийн малчнаар ажилласан хугацааг тодорхойлох “Маргаан хянан шийдвэрлэх зөвлөл”-д 4-р улиралд 1 малчин иргэний холбогдох бичиг баримт болон өргөдлийг авч аймгийн Нийгмийн даатгалын газрын зөвлөлд хүргүүлснээр хэлэлцэн шийдвэрлэж малчнаар тэтгэвэр тогтоосон. | 1-12 сард | |
| | Арга хэмжээ 2.7 Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах; | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллана. | | Шалгалтын үр дүнг тухай бүрд нь тооцон, холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70%-с доошгүй барагдуулсан байна. | 2024 оны шалгалтын төлөвлөгөөний дагуу Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн хэрэгжилтийн талаар “Хан хөхий оргил” ажил олгогчид хяналт, шалгалт хийхэд 2022 оны 6 сараас эхлэн хүүхдээ асарч байгаа эхийн код 01 кодоор өөрчлөгдөх байсан боловч 06 кодоор 2022 оны 12 сарыг дуустал тайлан буруу өгсөн зөрчил гарсныг шалгаж акт тавьж 455700 төгрөгийн акт, 136710 төгрөгийн алданги нийлээд 592410 төгрөг төлүүлж холбогдох материалыг авч тайланд тусгуулан ажилласан бөгөөд ажилчдын албан тушаалыг тодорхой бичиж байх, сар бүр шимтгэлээ төлж өргүй гарах, тайланг хугацаанд хийх зөвлөгөө өгсөн. Ноён шим, Хүчит бэрс аж ахуйн нэгжүүдийн 2022-2023 оны санхүүгийн баримтанд хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу нийгмийн даагалын шимтгэл төлөлтийг харилцах, цалингийн баримт, НД-ын шимтгэлийн тайланг тус тус | 1-12 сар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үндэслэн шалгахад 2 даатгуулагчтай зөрчил илрээгүй бөгөөд сар бүр шимтгэлээ төлөх, хугацаандаа тайлангаа хийж байх зааварчилгаа зөвлөмж өгсөн. | | |
| | Арга хэмжээ 2.8 Тэтгэврийн хувийн хэрэг дэх баримт бичгийг эмхэлж цэгцлэн цахимжуулах ажлыг эхлүүлнэ. | Нийт хувийн хэргийг тоолж, тооллогын баримтаар хадгаламжийн нэгж үүсгэн, илэрсэн зөрчлийг арилгуулна. | | Хагас жилд цахимжуулсан хувийн хэргийн тоо | Сумын Засаг даргын 2022.04.22-ны А/83 тоот захирамж болон Нийгмийн даатгалын сангийн анхан шатны маягт цахимжуулах журмын дагуу тэтгэврийн хувийн хэрэгт хагас болон жилээр эцэст 2 удаа тооллого хийж мэдээ, тайланг гарган 2024.04сар 12 сард аймгийн НДГ-т файлаар болон цаасаар хүргүүлэн ажилласан. Тооллогын үр дүнд нь дутсан хувийн хэрэг байхгүй .Зогссон хувийн хэргийг тулгалт хийж аймгийн НДГ-ын архивт шилжүүлсэн. Мөн Засгийн газрын 2024.03.20-120 тогтоолын дагуу тэтгэврийн нэмэгдэлийг нийт 394 өндөр нас, болон хөдөлмөрийн чадвар түр алдсан, тэжээгчээ алдсаны тэтгэврийн хувийн хэрэгт бичилт хийж баталгаажуулсан. Тэжээгчээ алдсаны-9, хөдөлмөрийн чадвар алдалтын тэтгэвэр авагч-39, өндөр насны-59 тэтгэвэр авагчийн хувийн хэргийг сканардаж файл үүсгэн хадгалсан. | 1-12 сар | |
| | Арга хэмжээ 2.9 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн харилцах, шимтгэл төлөлтийн тайлан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг хадгаламжийн нэгж үүсгэн архивд хүлээлгэн өгч ажиллана. | Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байх | | Хүлээлгэн өгсөн ХН-ийн тоогоор | Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хүрээнд сумын 2023 оны Нийгмийн даатгалын сангийн харилцахын-9, ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан-2, ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн баримт-1, нөхөн даатгалын баримт-1, тэтгэвэр авагчийн зогссон хувийн хэрэг-13 баримтуудыг тус тус хадгаламжийн нэгж үүсгэн жагсаалт 2% үйлдэн хэлтсийн архивд хүлээлгэн өгч ажилласан. Өндөр насны тэтгэвэр авагч нас барсан-8, хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэвэр авагч зогссон-2, тэжээгчээ алдсаны зогссон-3 нийт 13 хувийн хэргийг 1-р улиралд жагсаалт үйлдэн аймгийн НДГ-ын архивт хүлээлгэн өгсөн. Мөн 2024 оны жилийн эцэст нас барсан өндөр насны тэтгэврийн хувийн хэрэг-8, хөдөлмөрийн чадвар алдалтын зогссон-3, тэжээгчээ алдсаны зогссон-2 нийт 13 хувийн хэргийг архивт хүлээлгэн өгсөн. Ажилгүйдлийн тэтгэмж авсан 8 иргэний баримтийг үдэж архивт өгсөн. | 1-12сар | |

**ГУРАВ.ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах" | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ 3.1 Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлж ажиллана. | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг 06 сарын 20-ны дотор НДГ-т хүргүүлнэ. | Аймгийн Нийгмийн даатгалын газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу архивт баримт өгөх, хувийн хэргийн тооллого хийх, 2023 онд малчнаар орон тооны бус зөвлөлөөр орж тогтоогдсон малчин тэтгэврийн хувийн хэрэг-2, ҮОМШӨ тогтоогдсон -1 тэтгэврийн хувийн хэргийг хяналт шалгалт хийх хугацаанд аймагт хүргүүлсэн. Мөн "Малчны орон тооны бус зөвлөл"-ийн баримтыг үдэж хяналт шалгалтын албанд тус тус хүргүүлсэн.12 удаа цагийн балансаа хугацаанд өгч цаасан хэлбэрээр, сар бүрийн 25-ны дотор тэтгэврийн файлыг тэтгэвэр хариуцсан байцаагчид өгөх зэрэг хугацаатай өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлж ажилласан байна. | | |
| | Арга хэмжээ 3.2 ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллана. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | | Иргэд, даатгуулагч, ААНБ-с ирсэн өргөдөл,гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж | ААНБ-аас ирсэн өргөдөл байхгүй. Тэтгэвэрт гарах 1 иргэний өргөдлийг 2024.06.05нд аймгийн НДГ-т хүргүүлсэн бөгөөд тус сумын Хүн эмнэлэгт ажиллаж байсан иргэн 1995 болон 2003 онд хүүхэд асарч байх хугацааны нийгмийн даатгал төлөгдөөгүйг хянаж акт тавьж тухайн байгууллагаар төлүүлж даатгуулагчийн ажилласан жилийг нь нэмж тэтгэврийг тогтоож шийдвэрлүүлсэн. Тэтгэвэрт гарах -24 иргэн, хчта -8, жа-7, ажилгүйдэл-8, оршуулгын тэтгэмж болон дараа сарын тэтгэвэр авах-6 иргэний болон нийт-45 иргэний өргөдөл гомдлын шийдвэрлэж цаг хугацаанд чирэгдэлгүй ажилласан. | | |
| | Арга хэмжээ 3.3 Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана. | Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулсан байна. ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд гаргасан байна. | | Авлига,гэмт хэрэг,зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар мэдлэгээ дээшлүүлж,үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана | Авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах мэдэгдэлд сумын Тамгын газрын дарга бүх төрийн албан хаагчдад хэвлэн тараж өгч, гарыг үсэг зурж ажлын байрандаа ил тод байршуулж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөн ажил олгогч, даатгуулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллах, мөн Төв аймгийн Нийгмийн даатгалын газарт иргэдийн үйлчилгээнд харгалзах товчийг дарж холбогдох ажилтнаас зөвлөгөө мэдээлэл, санал хүсэлт хүлээн авах лавлах утас: **70274004** дугаарт хандах мэдээллийг ажлын байрандаа ил байршуулан тавьсан. Мөн ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд үнэн зөв гаргаж өгсөн. Нийгмийн даатгалын ерөнхий | | - - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | газраас зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх хуулийн сургалтанд оролцсон. | | |
| | Арга хэмжээ 3.4 Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулна. | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан хүний тоо | | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг,мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | 2024 оны 1 сард тамгын газраас захирамж гарч 6 хэсэг болж малчин иргэддээ мэдээлэл хүргэж 2023 онд хийсэн ажилаа танилцуулж сумын сэтгүүлийг тарааж иргэдийн санал хүсэлтийг авч өвөлжилт хүндрэлтэй малчдын судалгаа гаргах Нийгмийн даатгалд малчнаар хамруулах хуулийн шинэчилсэн сурталчилгаа хийн 53 өрхийн 459 иргэнд үйлчилсэн. Мөн 1,2-р улирлын 3 багийн өдөрлөгт 6 удаа оролцож 263 иргэнд сургалт сурталчилгаа хийсэн. Сумын төрийн байгууллагууд 2024.04.23-ны өдөр "ШИЛДЭГ СУМ"-2024 он сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг Соёлын төвд зохион байгуулж 152 иргэн төрийн үйлчилгээг нэг дороос түргэн шуурхай хүргэн ажилласан. Ажлын тайлан мэдээг гаргаж БИНХурал, уулзалт өдөрлөг болон бусад олон нийтийн арга хэмжээн дээр тарааж нийт 150 гаруй иргэдэд мэдээллэж ажилласан бөгөөд тухайн олон нийтийн хүрээнд зохион байгуулагдсан ХАБЭА-н сарын аян, Найзаа ойлгоё арга хэмжээ, зорилтод өрхийн хүүхэд багачуудын дунд зохион байгуулсан бүтээлийн уралдаан зэрэг ажлыг цахимд байршуулсан.<br>" Даатгалтай ирээдүй "зорилтот сургалтыг<br>1 удаа зохион явуулж ахлах ангийн 10-11 ангийн 26 сурагч хамрагдаж "Үйлчилгээний нэгдсэн төв"-д ирж мэргэжил бүхэн сайхан гэж Нийгмийн даатгал, Татвар, Халамж, Газрын албаны ажилтай танилцаж хэлэлцүүлэг хэлбэрээр явагдаж тараах материалыг өгснөөр сумын ЕБС -ийн төгсөх ангийн сурагчдыг нийгмийн даатгалын ач холбогдолыг ойлгуулан ойр дотны болон хамрагдаагүй иргэдэд хэрхэн сургалтад хамруулан хамрах хүрээг нэмэгдүүлэхээр зөвлөгөө өгч ажилласан.<br>Төсвийн байгууллага,хаан, төрийн банкны салбарууд, шатахуун түгээх-2, багийн өдөрлөгт 6 удаа сургалт сурталчилгааг байгууллагын дарга болон багийн даргатай хамтран зохион байгуулсан. "Даатгалтай ирээдүй" сургалтыг Нийгмийн бодлого, Хөдөлмөр халамжийн мэргэжилтэнтэй хамтран ажилласан.Энэ онд нийт 20 удаа сургалт зохион байгуулж 671 даатгуулагч хамрагдсан байна. | | |
| 3. | Арга хэмжээ 3.5 Нийгмийн даатгалын багц хуулийн | Орон нутгийн хэвлэл | | Сум, орон нутгийнхаа | Сумын олон нийтийн ажилтанд улирал бүр буюу 2 удаа, хууль эрх зүйн мэргэжилтэнд улиралд 2 удаа | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ш…эчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчилна. | мэдээллийн хэрэгслээр зохион байгуулсан арга хэмжээний тоо, Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк)-д байршуулсан мэдээллийн тоо, хандалтын тоо. Бэлтгэсэн нэвтрүүлэг, видео шторк, контент, цахим хичээл, постерын тоо. Иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, зорилтот бүлгүүд буюу хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад зориулан зохион байгуулсан сургалт, сурталчилгаа, арга хэмжээний тоо, | | хэвлэл, мэдээллийн хэрэгсэл,пэйж хуудсаар дамжуулан нд-ын талаарх пост, лайв мэдээллийг үнэн зөв,ойлгомжтой хийсэн байна. | сэтгүүлд тавигдах Нийгмийн даатгалын байцаагчийн хийсэн ажлын мэдээллийг өгч нийтлүүлж, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар иргэд, даатгуулагчдад сумын “Арилжаа сурталчилгаа” болон өөрийн фэйсбүүк, төрийн албан хаагч, төрийн захиргаа гэсэн олон нийтийн сүлжээгээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын сайтад тавигдсан 18 мэдээллийг байршуулан даатгуулагч иргэдэд хүргэсэн. Эрүүл мэндийн даатгалыг И-баримтаа ашиглаж утаснаасаа төлөх, Нийгмийн даатгалын лавлагаа авах, тэтгэмж авах хүсэлтийг хэрхэн илгээх заавар зөвлөмжийг 1 удаа лайв хийж ажилласан.<br>” Даатгалтай ирээдүй “зорилтот сургалтыг<br>1 удаа зохион явуулж ахлах ангийн 26 сурагч хамрагдаж хэлэлцүүлэг хэлбэрээр явагдаж тараах материалыг өгснөөр сумын ЕБС -ийн төгсөх ангийн сурагчдыг нийгмийн даатгалын ач холбогдолыг ойлгуулан ойр дотны болон хамрагдаагүй иргэдэд хэрхэн сургалтад хамруулан хамрах хүрээг нэмэгдүүлэхээр зөвлөгөө өгч ажилласан. ЗДТГ, Сургууль, Соёлын төв, Цэцэрлэг, Эмнэлэг, Хаан болон төрийн банк, Ник, Би эс ойл гэсэн аж ахуйн нэгжүүдэд ажлын байранд нь очиж 156 даатгуулагчдад Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн сургалт хийж тараах материал, гарын авлага өгч цахимаар мэдээллийг авах, хүсэлт гаргах зэргийг зааж өгсөн. | | |

## ХОЁР.МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ,АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин /биелэлт / | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 4 | 5 6 | 7 | |
| 4.1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газар болон холбогдох дээд шатны байгууллагаас зохион байгуулсан сургалтад тухай бүрт бүрэн хамрагдана. | Сургалтад хамрагдсан тоогоор | 2-оос доошгүй сургалтанд хамрагдсан байна. | НДЕГ-ын зохион байгуулсан ажил олгогчийн тайлан хийх заавар заах цахим сургалтанд 1 удаа, шинэчилсэн хуулийн сургалтанд 1 удаа, Аймгийн НДГ-ын цахим хуралд 1 удаа тус тус хамрагдсан. Мөн аймгийн Иргэний бүртгэлийн цахим сургалтанд 1 удаа оролцсон байна. Мөн Сумын Засаг даргын тамгын газраас 4 баг болж 14 хоногт дотоодын сургалтыг зохион явуулж төрийн албан хаагчдад Нийгмийн даатгалын шинэчилсэн хуулийн мэдлэг өгч, сайтаас хэрхэн мэдээллийг авах заавар зөвлөгөөг албан хаагчдын гар утасан дээр дадлага хийлгэж сургалт орохын хамт өөрийн мэдлэг чадвараа дээшлүүлэх, идэвхжүүлэх сургалтанд 8 удаа хамрагдсан.Нийгмийн даатгалын ёрөнхий газраас 2024.10.28-2024.11.06 дуустал байцаагчдын эрх олгох болон баталгаажуулахад зориулсан сургалтанд хамрагдаж шалгалтаа амжилттай өгсөн. | 1-12 сар | |
| 4.2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм, Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм, Төрийн албан хаагчийн тангараг, НДГ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг тус тус чанд сахин биелүүлнэ | Бүрэн хэрэгжүүлсэн байна. | Зөрчил, гомдол гаргалгүй ажилласан байна | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм, Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм, харилцаа хандлагаа ямагт дээшлүүлэн иргэд, даатгуулагч, ажил олгогчийн хууль ёсны эрх ашгийг дээдлэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, төрийн албан хаагчийн тангаргийг чанд сахин биелүүлж ажилласнаар зөрчил болон иргэдээс гомдол гаргалгүй ажилласан байна. | 1-12 сар | |
| 4.3 | Жендерийн цахим модуль сургалтад бүрэн хамрагдана. | Зохион байгуулсан сургалтад бүрэн хамрагдсан байна. | Сургалтад хамрагдсан тоогоор | Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” сургалтын хөтөлбөрийн цахим сургалтанд Монгол бичгийн мэдлэг,ТАлбан хаагчийн санхүүгийн боловсролыг түвшин дээшлүүлэх, БНСУ-Талбан хаагчийн сонгон шалгаруулалтын тойм, Төрийн албан хаагчийн цалингийн системийн мэдээлэл, орчин үеийн хийсвэр оюун оюун ухааны мэдлэг, Нийгмийн даатгалын тухай ёрөнхий болон шинэчлэгдсэн хууль гэх мэт 9 удаа цахим сургалтанд хамрагдсан. Төрийн албан хаагчдын “Ахисан түвшний жендэр”, Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ үнэлгээний цахим сургалтанд амжилттай оролцож гэрчилгээ авсан. | 1-12 сар | |

87.9% (илүүр гарсан)

41

Хэргэжилт гаргасан:

Баянцогт сумын Нийгмийн даатгалын байцаагч............................(К.Дулмаа)

(Албан тушаал) (Нэр,гарын үсэг )

(Огноо) 2024.12.03